



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 01 сарын 22 өдөр

Дугаар А/16

Мандалговь

“Сайнцагаан сумын 6,7,8 байрны гадна фасад,
тохижилт, дээврийн зураг, төсөв боловсруулах” зөвлөхийн
үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах
үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Сайнцагаан сумын 6,7,8 дугаар байрны гадна фасад, тохижилт, дээврийн зураг, төсөв боловсруулах” зөвлөхийн үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Э.Чагнаадорж (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга)

Гишүүд: Ё.Дашням (Иргэний төлөөлөл)

Э.Энхмэнд (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн)

С.Адъяасүрэн (Санхүү төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: М.Бат-Эрдэнэ (Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн)

Хоёр. Үнэлгээний хороо тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Э.Чагнаадорж)-д даалгасугай.

Гурав. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (М.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

482060235